

ОЛОН УЛСЫН ИРГЭНИЙ ГҮЙЛГЭЭН ДЭХ ТӨРИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ

В. Оюумаа¹

Төрийн тухайд зөвхөн хууль зүйн шинжлэх ухааны үүднээс² авч үзвэл хэд хэдэн талаас нь судлан тодорхойлж болох эрх зүйн олон талт үзэгдэл мөн. Тухайлбал академич С.Нарангэрэл төр гэсэн ухагдахууныг эрх зүйн онолын³, үндсэн хуулийн эрх зүйн⁴, олон улсын эрх зүйн⁵ үүднээс тайлбарласан байна. Олон улсын харилцаанд төрийн оролцоогоор нөхцөлдсөн асуудал бүхэлдээ энэхүү судалгааны зүйлд ороогүй бөгөөд харин зөвхөн олон улсын хувийн эрх зүйн харилцаанд төр оролцсон асуудлыг тусгайлан авч үзэх болно.

Олон улсын хувийн эрх зүйн номлолын дагуу төр нь олон улсын хувийн эрх зүйн харилцаанд нийтийн эрх мэдлийг илэрхийлэгч, бүрэн эрхт субъект (*jure imperii*) болон хувийн ашиг сонирхлыг илэрхийлэгч, аж ахуйн субъект (*jure gestionis*) гэсэн хэлбэрээр оролцож болно. Эхний эрх зүйн харилцаа нь олон улсын эрх зүйн субъектын (улс, үндэстэн ба ард түмэн, олон улсын байгууллага) харилцан үйлдлийн явцад бүрэлдэж, олон улсын нийтийн эрх зүйн (*jus publicum*) хэм хэмжээгээр зохицуулагдана. Хоёр дахь эрх зүйн харилцаа нь нэг талаас төр нөгөө талаас аж ахуй эрхэлж буй олон улсын субъект, эсхүл гадаадын хуулийн этгээд, гадаадын иргэний хоорондын харилцан үйлдлээр үүсч, хувийн эрх зүйн (*jus privatum*)⁶ хэм хэмжээгээр зохицуулагдана.

Ийнхүү төр засаглах бүрэн эрхээ өөр төртэй харилцах харилцаагаар хэрэгжүүлэх төдийгүй

¹ МУИС, ХЗС-ийн ахлах багш

² Төрийн тухай онолын асуудлыг Монголын эрдэмтэн судлаач Сарантуяа Ц. Төрийн ерөнхий онол. Улаанбаатар. 1998; Лүндэндорж Н. Төр, эрх зүйн сэтгэлгээний хөгжлийн чиг хандлага. Улаанбаатар. 2002; Лүндэндорж Н. Төрийн онол. Нэмж засварласан гурав дахь хэвлэл. Улаанбаатар. 2008; Жалан-Аажав С. Төр, эрх зүйн онол. Улаанбаатар. 2000; Нямсүрэн Ч. Эрх зүй, төрийн ерөнхий онол. Улаанбаатар. 2001 зэрэг номоос тодруулж үзнэ үү.

³ Академич С.Нарангэрэл төр нь “эрх зүйн онолд үндсэн бүрэлдэхүүн хэсэг нь улс төрийн тогтолцоо, нийтийн засаг төрийн улс төрийн зохион байгуулалт бөгөөд түүний албан ёсны төлөөлөгчид нь нийт нийгмийн төлөөллөөс бүрэлддэг, зайлшгүй шаардлагатай тохиолдолд албадлагын арга хэрэглүүр ба арга хэмжээнд тулгуурладаг нийгмийн зохион байгуулалтын тодорхой арга. Нийгмийг удирдах тогтолцоо болохын хувьд дотоод бүтэцтэй байх бөгөөд өөрийн бүрэн эрхийг хэрэгжүүлэхийн тулд тусгай байгууллага болох төрийн механизм, түүний аппаратыг буй болгосон байна” гэж тайлбарлажээ. - Нарангэрэл С. Эрх зүйн эх толь бичиг. Хоёр дахь хэвлэл. Улаанбаатар, 2008. 410 дахь тал.

⁴ Академич С.Нарангэрэл төрийн ухагдахууныг үндсэн хуулийн эрх зүйн үүднээс хэрхэн тайлбарласныг Нарангэрэл С. Эрх зүйн эх толь бичиг. Хоёр дахь хэвлэл. Улаанбаатар, 2008. 411 дэх талаас тодруулж үзнэ үү.

⁵ Академич С.Нарангэрэл төрийн ухагдахууныг олон улсын эрх зүйн үүднээс “олон улсын харилцааны үндсэн оролцогч болох олон улсын эрх зүйн субъект. Төр нь дараах үндсэн шинжийг агуулна: тодорхой бөгөөд тогтмол суурьшилтай хүн амтай тодорхой нутаг дэвсгэртэй засаг төр ба хүн амын улс төрийн зохион байгуулалт нь нутаг дэвсгэртээ үр нөлөөтэй үйл ажиллагаа, хяналт хэрэгжүүлэх боломжтой олон улсын хамтын ажиллагааг хэрэгжүүлэх эрх зүйн чадамжтай. Засаг төрийн улс төрийн зохион байгуулалт болохын хувьд төр нь олон улсын тавцанд, ялангуяа түүний дээд байгууллага нь төрийн албан ёсны төлөөлөгчийн хувиар олон улсын эрх зүйн субъект болно. Төр олон улсын эрх зүйн субъект болохыг нотлон харуулдаг үндсэн гол шинж нь түүний бүрэн эрхт байдал” хэмээн тайлбарлажээ. - Нарангэрэл С. Эрх зүйн эх толь бичиг. Хоёр дахь хэвлэл. Улаанбаатар, 2008. 411 дэх талаас тодруулж үзнэ үү.

⁶ Богуславский М.М. Международное частное право: Учебник. М., 2000. С.149; Звеков В.П. Международное частное право. Курс лекций. М., 1999. С.230-231; Quadri Rolando. Diritto internazionale pubblico. 5-ed., rist. Napoli, 1980. P. 616.

хувь этгээд буюу хуулийн этгээдтэй тодорхой харилцаанд орж, олон улсын иргэний эргэлтийн субъект болж болно.

Үүнтэй холбогдуулан зарим судлаачид “төр нэг тал нь болж байгаа бүхий л эрх зүйн харилцааг бид нийтийн эрх зүй хэмээдэг”⁷ гэж бичсэнтэй санал нийлэхэд төвөгтэй байгаа юм. Хэрэв тухайн харилцааны оролцогч нь төр байгаа ч “босоо” буюу “захирах-захирагдах” загвартай, императив аргаар зохицуулж байгаа бол нийтийн эрх зүй, харин уг нийгмийн харилцаа “хэвтээ” буюу “эрх тэгш” загвартай байгаа бол тухайн харилцаанд хувь этгээд, хуулийн этгээд, эсхүл төр субъект болж байгаагаас үл хамааран хувийн эрх зүйн хүрээнд хамаарна.

Олон улсын эрх зүйн субъектын хоорондын маргааныг НҮБ-ын дүрмийн 33 дугаар зүйлд⁸ нийцүүлэн хянан үзэж НҮБ-ын Олон улсын шүүхэд шийдвэрлэнэ.

Төр болон аж ахуй эрхэлж буй гадаадын субъектын хоорондын эрх зүйн харилцаа нь олон улсын хувийн эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагдах бөгөөд “олон улсын эрх зүйн энэхүү харилцааг харилцаанд оролцогч хувь этгээд болон хуулийн этгээдийн төрийн эрх зүйд захирагдан зохицуулахгүй бөгөөд зохицуулж ч болохгүй”⁹ юм. Эдгээр субъектын хоорондын эрх зүйн харилцаанаас үүдсэн маргааныг тухайн маргааныг хянан үзэх эрх хэмжээ бүхий алив нэг төрийн нийтлэг шүүх буюу арбитрын шүүх хянан шийдвэрлэнэ.

Олон улсын хувийн эрх зүй дэх төрийн эрх зүйн байдал нь иргэн болон хуулийн этгээдийн түүний эрх зүйн байдлаас ялгагдана. Энэ нь юуны өмнө “төр өмчийн эрх болон төрийн дээд эрх мэдлийг илэрхийлэгч байдаг”¹⁰-аар нөхцөлдөнө.

Олон улсын хувийн эрх зүйн субъект хоорондын эд хөрөнгийн харилцаанд ороход төр онцгой байр суурийг эзэлнэ. Энэ нь хэд хэдэн объектив болон субъектив шалтгаанаар нөхцөлдсөн байдаг. Тухайлбал, төрийн гурван шинж (тодорхой нутаг дэвсгэр, түүнд оршин буй хүн ам, эрх мэдэл)¹¹, төрийн дархан эрх, гадаадын аж ахуйн субъект болон төр хоорондын аливаа гэрээний улс төрийн далд шалтгаан болно.

Үүнээс гадна төрийн хууль зүйн ач холбогдол бүхий тодорхой үйлдэлд төрийн өмчлөгчийн эрх болон бүрэн эрхт байдлын илэрхийлэгчийн шинж нэгэн зэрэг илэрч байдаг.

Хууль зүйн ном зохиолд гадаад эдийн засгийн иргэний эрх зүйн харилцаанд төр оролцохдоо өөрийн бүрэн эрхт байдал болон өөрийн засаглах чиг үүргээ бүрэн хэмжээгээр хэвээр хадгалдаг гэсэн санааг бичсэн байдаг.

Зарим судлаач “төр нь иргэний үүрэгчлэлд оролцохдоо төрөөс улс төрийн эрх мэдлээ хадгалсан хэвээр байдаг учраас иргэний эрх зүйн ердийн субъект болон хэзээ ч хувирдаггүй”¹² гэсэн байна. Яг үүнтэй төсөөтэй байр суурийг дэмжиж зарим судлаач “... нэг ба хоёр дахь хувилбарт (нэг дэх нь төрийн түншлэгч нь өөр төр буюу олон улсын байгууллага, хоёр дахь нь төр эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус харилцаанд гадаадын хуулийн ба хувь этгээдтэй оролцсон үед...) төр нь өөрийн бүрэн эрхт байдлын шинжээ алддаггүй”¹³ гэж бичжээ.

Өмнө дурдсан үзэл бодолтой санал нийлэхэд ихээхэн төвөгтэй бөгөөд учир нь иргэний эрх зүйн харилцаанд оролцогчид нь “хэвтээ” буюу талууд нь эрх тэгш байх зарчимтай зөрчилдөж, иргэний эрх зүйн шинжтэй эд хөрөнгийн харилцааг агуулгын хувьд төсөөтэй боловч (жишээлбэл, дотоод эргэлтэд нь төр оролцсон тохиолдолд санхүүгийн эрх зүйгээр, гадаад эргэлтэд нь төр оролцсон тохиолдолд олон улсын эрх зүйгээр зохицуулагдах) эрс ялгагдах салбарын харилцаанаас зааглан ялгах боломжгүй болгож байна.

⁷ Ушаков Н.А. Государство в системе международно-правового регулирования. М., 1997. С.34

⁸ Төрийн мэдээлэл. Тусгай дугаар., 11 боть. Монгол улсын олон улсын гэрээ. Улаанбаатар., 2005. 270-302 дахь тал.

⁹ Ушаков Н.А. Государство в системе международно-правового регулирования. М., 1997. С.34.

¹⁰ Брагинский М.И. Участие советского государства в гражданских правоотношениях. М., 1981. С.67.

¹¹ Ушаков Н.А. Государство в системе международно-правового регулирования. М., 1997. С.67.; Ануфриева Л.П. Соотношение международного публичного и международного частного права: правовые категории. М., 2002. С.23-28., Лүндэндорж Н. Төрийн онол. Нэмж засварласан хоёр дахь хэвлэл. Улаанбаатар. 2005. 37 дахь тал.

¹² Виткявичус П.П. Гражданская правосубъектность советского государства. Вильнюс, 1978. С.173.

¹³ Ануфриева Л.П. дурдсан зохиол. С.27.

Олон улсын иргэний эргэлтэд төрийн эрх зүйн байдлын онцлог нь олон улсын нийтийн эрх зүйн үндсэн зарчим болох улсуудын бүрэн эрхт байдлын эрх тэгш зарчимаас шууд урган гардаг юм. Энэ зарчим НҮБ-ын Дүрмийн 2 дугаар зүйлийн нэг дэх хэсэгт “Тус байгууллага нь бүх гишүүнийхээ адилхан бүрэн эрхт байдлын зарчим дээр үндэслэнэ”¹⁴ хэмээн зааснаар илрэлээ олсон юм.

Төр нь олон улсын харилцаанд олон улсын эрх зүйн бүрэн эрхт, тусгаар тогтносон субъектээр оролцоходоо бие биетэйгээ эрх тэгш зарчмын үндсэн дээр оролцоно. Тухайлбал, олон улсын эрх зүй нь олон улсын эрх зүйн бүрэн эрхт субъект болох төрийн аливаа харилцаанд тэдгээрийн хоорондын ялгаанаас үл шалтгаалан өөр хоорондоо эрх тэгш байх нийтлэг зөвшилцөлд суурилдаг.

Төрийн бүрэн эрхт байдал, эрх тэгш байдлын зарчмыг зөв ойлгож хэрэглэхэд бусад зарчимтай нягт уялдаа холбоотой авч үзэх зүй ёсны шаардлага үүсдэг. Аливаа нэг зарчмыг зөрчих нь бас нөгөөг нь зөрчихөд хүргэдэг. Ийм учраас төрийн бүрэн эрхт байдлыг хүндэтгэх, бусдын дотоод хэрэгт хөндлөнгөөс үл оролцох, олон улсын үл ойлголцлыг шийдвэрлэхэд хүч үл хэрэглэх нь тэдгээрийн нийгэм-эдийн засгийн тогтолцоо, хүчин чадал, том багын хэмжээ, санхүүгийн байдлын ялгаанаас үл шалтгаалан төрийн бүрэн эрхт байдлын үндсэн дээр олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх баталгаа болдог байна.¹⁵

Бүрэн эрхт байдлын зарчим нь юуны өмнө “бүрэн эрхт байдал” ба “тэгш эрх” гэсэн хоёр ухагдахууны хослолоор тодорхойлогдох нарийн утга агуулгатай юм.

Төрийн бүрэн эрхт байдлын¹⁶ ухагдахуун нь төр ба тэдгээрийн тусгаар тогтнол-бүрэн эрхт байдал хууль зүйн хувьд эрх тэгш байна гэсэн хэрэг юм. Бүрэн эрхт байдал төрд байх хэвшмэл шинж юм. Төрийн бүрэн эрхт байдал нь олон улсын харилцаанд төрийн үндсэн нэн чухал эрх ба үүрэг болдог.

Олон улсын эрх зүйн хүрээнд бүх төр эрх тэгш эрх, үүрэгтэй байдаг. Бүр эртний Ромд төрийн эрх тэгш байдал нь “*par in parem non habet imperium*” өөрөөр хэлбэл, “эрх тэгш эрхтэй эрх тэгш эрх мэдэл гэж байхгүй”, “*par in parem non habet iurisdictionem*” - “эрх тэгш эрхтэй эрх тэгш шүүн шийдвэрлэлт гэж байхгүй”, “*par in parem non habet potestas*” - “эрх тэгш эрхтэй эрх тэгш бүрэн эрх гэж байхгүй” гэсэн томъёоллоор илэрхийлэгдэж байжээ.

Бүрэн эрхт байдал бол төрийн үндсэн мөн чанар юм. Эрдэмтэн Б.Чимид “... олон улсын эрх зүйд “суверенитет” гэх нэр томъёогоор илэрхийлдэг энэ ойлголтыг бид “бүрэн эрхт байдал” гэж монголчлон хэрэглэдэг. Түүний үнэнхүү гол агуулга нь тухайн улсын төрийн эрх мэдэл нутаг дэвсгэртээ хуваарьгүй дангаар ноёрхож, гадаад улс төрийн бодлого, зарчмаа бусдын оролцоо, дарамтгүйгээр өөрөө тодорхойлж бие даан явуулахад оршино”¹⁷ гэж бичжээ.

Академич С.Нарангэрэл “Төрийн бүрэн эрхт байдал нь улс орны дотоодод төрийн эрх мэдлийг дээдлэх, гадаад хүрээнд хараат бус, бие даасан байх, өөрөөр хэлбэл аливаа харийн эрх мэдлийг үгүйсгэсэн хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдэл тухайн улсын нутаг дэвсгэрт бүрэн тогтоогдож, түүнчлэн олон улсын амлалтын хүрээнд гадаад улсын эрх мэдэлд эс захирагдах явдал юм”¹⁸ гэж тодорхойлсон байна.

Хууль зүйн шинжлэх ухааны доктор Н.Лүндэндорж “Төрийн эрхт байдал – тухайн улсын нутаг дэвсгэр дээр түүнтэй зэрэгцсэн эсвэл тэнцэхүйц өөр эрх мэдэл үл оршиж, улс орны хэмжээнд хууль ёсоор хүлээн зөвшөөрөгдөж, дээдлэгдэж, олон улсын харилцааны түвшинд бие даан, харьцангуй хараат бус орших чадвар мөн”¹⁹ гэсэн байна.

Төрийн бүрэн эрхт байдлын хууль зүйн үндсэн шинжийг хоёр янзаар авч үзэж болохоор

¹⁴ Төрийн мэдээлэл. Тусгай дугаар., 11 боть. Монгол улсын олон улсын гэрээ. Улаанбаатар., 2005. 272 дахь тал.

¹⁵ Бараташвили Д.И., Принцип суверенного равенства государств в международном праве. М., 1978. С.56.

¹⁶ Академич С.Нарангэрэл төрийн бүрэн эрхт байдлыг “тухайн улсын төрийн эрх мэдэл нутаг дэвсгэртээ дангаар ноёрхож, гадаад улс төрийн бодлого, зарчмаа бусад улсын хөндлөнгийн оролцоо, дарамтгүйгээр өөрөө тодорхойлж, бие даан явуулах” гэж тодорхойлжээ. - Нарангэрэл С. Эрх зүйн эх толь бичиг. Хоёр дахь хэвлэл. Улаанбаатар, 2008. 413 дахь тал.

¹⁷ Чимид Б. Үндсэн хуулийг дээдлэх ёс. Улаанбаатар, 2006. 62 дахь тал.

¹⁸ Нарангэрэл С. Эрх зүйн эх толь бичиг. Хоёр дахь хэвлэл. Улаанбаатар, 2008. 83 дахь тал.

¹⁹ Лүндэндорж Н. Төрийн онол. Нэмж засварласан гурав дахь хэвлэл. Улаанбаатар. 2008. 52 дахь тал

байна. Нэгдүгээрт, улсын нутаг дэвсгэрт байгаа бүх этгээд, байгууллага төрд захирагдах, төрөөс тэдэнд хамаарах эрх зүйн дэг журмыг тогтоох, түүнчлэн төрийн эрх мэдлийн нэгдэл ба хууль зүйн хязгааргүй байдлыг илэрхийлсэн төрийг дээдлэх явдал юм. Хоёрдугаарт, төрийн хууль зүйн ба улс төрийн салшгүй уг шинж болсон олон улсын харилцаа дахь түүний хараат бус байдал буюу тухайн төр нь өөр төрд ямар нэгэн гадаад эрх мэдлийн хувьд эс захирагдах явдал юм.

Энэхүү үүднээс авч үзвэл төрийн бүрэн эрхт байдал болон олон улсын эрх зүйн хоорондын харилцан уялдаа холбооны асуудал сонирхол ихээхэн татдаг. Энэ хоёр ухагдахууны харьцааны тухай асуудлаар тодорхой цаг үед эрдэмтдийн сургаал янз бүр байж ирсэн түүхтэй. Энэхүү асуудалд амьдрал ч өөрөө хариулт өгч байна. Олон улсын эрх зүйн хэм хэмжээг удирдлага болгосон төр бүрэн эрхт байдлаа хэвээр хадгалж үлдэнэ. Үүний тод илрэл нь олон улсын байгууллага (НҮБ, Европын Холбоо), Гаг дахь Олон улсын шүүх, Страсбург дахь Хүний эрхийн Европын шүүх зэрэг юм.

Ялангуяа Страсбург дахь хүний эрхийн Европын шүүх нь бүрэн эрхт төрийн эсрэг иргэдийн гомдлоор шийдвэр гаргадаг. Энэ шүүхийн актыг Европын холбооны гишүүн - бүх улсууд хүлээн зөвшөөрч, хэрэгжүүлдэг билээ.

Олон улсын эрх зүйг үндэсний эрх зүйгээс илүү дээдлэх нь бүрэн эрхт байдлыг хязгаарлаж болзошгүй тухай санаа гарч ирдэг. Зарим судлаач “төр туйлын бүрэн эрх эдэлдэг гэдэг нь өөр төртэй харилцахад холбоогүй бөгөөд гагцхүү өөрийнхөө үзэмжээр төрийн гадаад ~~эрх~~ буюу олон улсын ёс суртахууны хүрээнд дэг журам тогтоож, энэ харилцааны агуулга, олон улсын эрх зүйг төдийгүй төрийн бүрэн эрхт байдлыг үгүйсгэж, энэ нь хамгийн хүчтэй өөр төрийн үзэмжээс бүрэн буюу бүхэлдээ шалтгаалах болно”²⁰ гэж үздэг. Германы эрдэмтэн Г.Еллинек төрийн бүрэн эрхт байдлын талаар судлаад “бүрэн эрхт байдал бол туйлын биш гэдгийг түүх бидэнд итгүүллээ. Бүрэн эрхт байдал нь төрийн үндсэн шинжийг тодорхойлоход нэн чухал ухагдахуун”²¹ гэж бичсэн байна.

Ийнхүү олон улсын эрх зүйн утга санаагаар авч үзвэл төрийн бүрэн эрхт байдал нь туйлын бус, хязгаармагдмал байх учиртай аж. Тэгэхдээ дэлхийн хамтын нийгэмлэгийн хөгжлийн объектив зүй тогтол, эрс өөр янз бүрийн төр оршин байгаагаар хязгаарлагддаг байна. Олон улсын эрх зүй нь бүрэн эрхт байдлыг гагцхүү иргэн, нийгэм, бүх дэлхийн ашиг сонирхлын үүднээс хязгаарлах бөгөөд тухайн төр өөрийн нутаг дэвсгэрт дур зоргоороо авирлаж, хэмжээ хязгааргүй эрх мэдэл хэтрүүлэн эдэлж, юу хүссэнээ гүйцэлдүүлж, нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчимаас гажиж болохгүй.

Төрийн бүрэн эрхт байдал бол хууль зүйн нарийн төвөгтэй ойлголт боловч, төрийн дархан эрхийн мөн чанар ялангуяа олон улсын хувийн эрх зүйн харилцаанд төрийн оролцооны онцлогийг ойлгоход ихээхэн ач холбогдолтой байдаг.

Иргэний эд хөрөнгийн харилцаанд орохдоо төр түүнд тогтоосон дэглэмд захирагдана. Энэ нь дараах байдлаар илрэлээ олно: Нэгдүгээрт, энэ оролцоо ямар ч хэлбэрээр хэрэгжсэн ч иргэний эрх зүйн эд хөрөнгийн харилцаанд төр цаг ямагт эд хөрөнгөөр нөхцөлдсөн субъект болдог. Хоёрдугаарт, Төр иргэний эрх зүйн эд хөрөнгийн харилцаанд цаг ямагт нөгөө субъекттэйгээ тэгш эрхийн үндсэн дээр оролцоно.

Төр бол иргэний эрх зүйн харилцааны субъект мөн. Монгол улсын иргэний хуулийн 7 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Төр, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж болох аймаг, нийслэл, сум, дүүрэг нь иргэний эрх зүйн харилцаанд хуулийн этгээдийн нэгэн адил оролцоно”²² гэж заасан байна.

Үүнээс үзэхэд төр иргэний эрх зүйн харилцаанд хуулийн этгээдийн нэгэн адил оролцож болно. Ийнхүү төр нь иргэний эрх зүйн харилцааны бусад субъект – иргэн ба хуулийн этгээдтэй эрх тэгш байдалтайгаар иргэний хууль тогтоомжоор зохицуулагдах харилцаанд оролцоно. Энэ

²⁰ Ушаков Н.А. Государство в системе международно-правового регулирования. М., 1997. С.73

²¹ Еллинек Г. Общее учение о государстве. Перевод под ред. Гессена В.М., Шалланда Л.В. СПб. 1913, С.312.

²² Монгол улсын хууль. Эмхэтгэл. дөрөвдүгээр боть. Улаанбаатар, 2008. 362 дахь тал.

утгаараа иргэний хууль тогтоомжоор зохицуулагдах эрх зүйн харилцаанд “төр” ба “хуулийн этгээд” хэмээх ухагдахуун нь эрх тэгш ухагдахуун юм. Монгол улсын нэрийн өмнөөс төрийн эрх мэдлийн байгууллага нь өөрийнхөө эрх хэмжээний хүрээнд эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хувийн эрх ба үүргийг олж авч хэрэгжүүлж, түүнчлэн шүүхээр хамгаалуулна.

Энд тэмдэглэсэн иргэний хууль тогтоомжоор зохицуулагдах харилцаа нь Монгол улсын иргэний хуулийн 1 дүгээр зүйлд “Энэ хуулийн зорилт нь эрх зүйн этгээдийн хооронд үүсэх эдийн болон эдийн бус баялагтай холбоотой харилцааг зохицуулахад оршино”, “Иргэний хууль тогтоомж нь иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдын эрх тэгш, бие даасан байдал, өмчийн халдашгүй байдал, гэрээний эрх чөлөө, хувийн хэрэгт хөндлөнгөөс оролцохгүй байх, иргэний эрх үүргийг ямар нэгэн хязгаарлалтгүйгээр хэрэгжүүлэх, зөрчигдсөн эрхийг сэргээлгэх, шүүхээр хамгаалуулах зарчимд үндэслэнэ”²³ гэж зааснаар тодорхойлогдоно. Монгол улсын Үндсэн хуулийн 14.2-т “...хүн бүр эрх зүйн этгээд байна” гэж заасан.

Үндсэн хууль болон иргэний хуулийн аль алинд заасан энэхүү “эрх зүйн этгээд” гэсэн ухагдахуун нь “... гагцхүү хүн байна гэсэн ойлголт биш юм. Эрх зүйн этгээд гэдэгт нийгмийн харилцаанд оролцогч бодгаль (хүн), хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллага, төр, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж хамаарагдана”²⁴.

Хуульд тусгасан ийм байр суурь нь зүй ёсны юм. Хуулийн этгээдийн категори нь улс бүрийн үндэсний эрх зүйн категори юм. Ийнхүү төр нь эрх зүйн чадамж бүхий олон улсын хувийн эрх зүйн онцгой оролцогч бөгөөд иргэний эрх ба үүрэг эдэлж, гадаадын зүйл (элемент) бүхий иргэний эрх зүйн харилцаанд оролцдог байна.

Гадаадын зүйл (элемент) бүхий эд хөрөнгийн харилцаа гэсэн ухагдахуун нь олон улсын хувийн эрх зүйн нэн чухал нэр томъёоны нэг юм. Эл нэр томъёог нэг мөр зөв ойлгож хэрэглэх нь олон улсын хувийн эрх зүйн гол чухал асуудлыг шинжлэх ухааны үндэстэй авч үзэх тулгын чулуу болдог юм. Манай улсын хууль зүйн ном зохиолд эл нэр томъёо хэрэглэгдэх болсон. Жишээлбэл, доктор Т.Мэндсайхан “гадаад элемент” гэсэн нэр томъёо хэрэглэж, “Олон улсын хувийн эрх зүйд гадаад элемент гэсэн ойлголт хэрэглэгддэг ба иргэний эрх зүйн аливаа харилцаа нь түүний бүрэлдэхүүнд “гадаадын элемент” оролцсон үед олон улсын шинжтэй болно.

Гадаадын элемент орсноор тухайн иргэний эрх зүйн харилцаа шинэ өөр мөн чанартай болж, зохицуулалтын өөр арга, арга ажиллагаа шаардагдана. Гадаадын элементийг 3 хэсэгт хуваан үзэж болно. Үүнд:

(1) *Эрх зүйн харилцааны субъект.* Хэрэв тухайн иргэний эрх зүйн харилцаанд оролцогчид нь өөр улсын иргэд ба хуулийн этгээд байвал энэ нь олон улсын шинжтэй болно. Жишээ нь, олон улсын худалдааны гэрээ байгуулах, Монгол улсын иргэн гадаадын иргэнтэй гэрлэх г.м.

(2) *Эрх зүйн харилцааны объект.* Хэрэв иргэний эрх зүйн аливаа гадаад улсад байгаа эд хөрөнгө, оюуны өмчийн талаарх бол олон улсынх байна. Жишээ нь, Монгол улсын иргэдийн хооронд хийгдсэн гэрээний зүйл болох эд зүйл гадаад улсад оршин байх, татан буугдаж буй Монгол улсын нэг компанийн өмч нь гадаад улсад байх, Монголын нэг зохиолчийн ном бүтээл гадаад улсад хэвлэгдэн гарах г.м.

(3) *Хууль зүйн факт.* Гадаад улсын нутаг дэвсгэр дээр болж буй хууль зүйн фактын үндсэн дээр иргэний эрх зүйн харилцаа үүсч, өөрчлөгдөж, эсвэл дуусгавар болж байвал уг харилцаа олон улсын шинжтэй болно. Жишээ нь Монгол улсын иргэд ОХУ-д байхдаа гэр бүл болох, БНХАУ-д хээрийн түймэр гарсны улмаас Монгол улсын иргэдэд гэм хор учрах гэх зэргээр бичсэн байдаг.

Дээр дурдсан гадаадын элементүүдээс аль нэг нь оролцсон иргэний эрх зүйн харилцаа

²³ Монгол улсын хууль. Эмхэтгэл. дөрөвдүгээр боть. Улаанбаатар, 2008. 361 дэх тал.

²⁴ Кают Ё., Шпанглер., Редел П., Хелмхаген., Наранчимэг Д., Амарсайхан Ц., Дүгэржав Д., Баярмаа Н. Монгол улсын иргэний хуулийн тайлбар. (срөнхий анги). Улаанбаатар. 2005, 8-9 дэх тал.

нь олон улсын хувийн эрх зүйн зохицуулах зүйлд хамаарна”²⁵ гэж үзжээ. Олон улсын хувийн эрх зүйн нэрт эрдэмтдийн нэг М.М. Богуславский эд хөрөнгийн харилцаанд гадаадын (олон улсын) зүйл (элемент) дараах гурван үндсэн эд хөрөнгийн харилцаанд оршино гэж үзсэн байна. Үүнд:

а) гадаадын (гадаадын иргэн, байгууллага, улс) тал субъект нь болж оролцсон эд хөрөнгийн харилцаа;

б) бүх оролцогчид нь нэг улсын иргэн боловч гадаадад буй болсон, оршин байгаа объекттой холбоотой эд хөрөнгийн харилцаа (жишээ нь өв залгамжилсан эд хөрөнгө);

в) гадаадад болсон хууль зүйн үйл баримт үүссэн, өөрчлөгдсөн буюу дуусгавар болсон эд хөрөнгийн харилцаа (жишээ нь гэм хор учруулсан буюу тухайн улсын иргэн нас барсан, тухайн улсын аж ахуйн нэгж гэрээ байгуулсан зэрэг)²⁶.

Олон улсын хувийн эрх зүйн нэрт эрдэмтэн М.М. Богуславскийн “Олон улсын хувийн эрх зүй” хэмээх олон удаагийн редакц бүхий сурах бичгийг монгол хэлнээ хөрвүүлэхдээ манай улсын эрдэмтэн судлаачид эл нэр томъёог “гадаадын этгээдийн оролцоотой” нэхэмжлэлийг тухайн улсын өөрийнх нь шүүхэд гаргах асуудал яригдана²⁷ гэж орчуулжээ. Манай улсад эл нэр томъёог академич С.Нарангэрэл “Гадаадын зүйл бүхий” гэж бүтээлдээ оноосон байна.²⁸

Монгол улс 1990-ээд оноос эхлэн иргэний эрх зүйн харилцаанд оролцох орчин үеийн хандлага 1994 оны шинэчлэн найруулсан Монгол улсын иргэний хуульд²⁹ тусгалаа олсон юм. Энэ хандлагыг 2002 оны Монгол улсын иргэний хуулиар улам бататгасан юм.

Монгол улсын дагаж мөрдөж буй Иргэний хуулийн 7 дугаар зүйлийн гурав дахь хэсэгт заасны дагуу төр нь иргэний хууль тогтоомжоор зохицуулагдах эрх зүйн харилцаанд бусад оролцогчидтой эрх тэгш оролцоно. Төр нь иргэний эрх зүйн үүрэгчлэлээ хуулийн этгээдэд аж ахуй эрхлэх буюу эсхүл шуурхай удирдах эрхээ олгоогүй эд хөрөнгийн хүрээнд хариуцна.

Төр иргэний эрх зүйн чухам ямар харилцаанд голчлон оролцож байна вэ гэдэг нь энэхүү судалгааны нэг гол зүйл юм. Бидний үзэж байгаагаар хэрэв Монголын төр нь дараах харилцаанд зөвхөн нэг тал нь болон оролцож байгаа тохиолдолд олон улсын нийтийн эрх зүйгээр бус харин олон улсын хувийн эрх зүйгээр зохицуулагдана.

Тухайлбал, Монголын төр нь:

- Зээл олгох буюу авах харилцаа (Монгол улс нь зээлдэгчийн адил зээлийн байгууллага, гадаадын төр ба олон улсын санхүүгийн байгууллагатай зээлийн хэлэлцээр байгуулж болно.);
- Монгол улсын нэрийн өмнөөс үнэт цаас гаргах замаар гүйцэтгэх зээллэгийн хэлбэрийг хэрэглэх;
- Зээллэг ба зээлийн баталгаа гаргах (Монгол улс нь Монголын төрөөс баталгаа гаргах тухай гэрээ байгуулж болно. Засгийн газраас баталгаа гаргах асуудал нь төсвийн тухай хуулиар зохицуулагдана.);
- Хилийн чанадад эдэлбэр газартай болох, түрээслэх;
- Хилийн чанад дахь өөрийн мэдлийн эдэлбэр газар, барилга байгууламжийг худалдах ба түрээслэх;
- Гадаадын хөрөнгө оруулагчидтай концессын гэрээ байгуулах;
- Бүтээгдэхүүн хуваах тухай хэлэлцээр нэн тэргүүнд газрын тос олборлох ба газрын тос боловсруулах аж үйлдвэрт томоохон хөрөнгө оруулах тухай хэлэлцээр байгуулах;
- Төрийн хэрэгцээнд зориулан ажил гүйцэтгэх гэрээ байгуулах;
- Бараа худалдах худалдан авах болон үйлчилгээ үзүүлэх зэрэг гэрээ байгуулах;

²⁵ Мэндсайхан Т. Олон улсын хувийн эрх зүй. Улаанбаатар. 2002, 4-5 дахь тал.

²⁶ Полковников Г.В. Международное частное право. Словарь – справочник., М., 2005, С.67-68.

²⁷ Богуславский М.М. Олон улсын хувийн эрх зүй. Сурах бичиг тав дахь хэвлэл. (Орчуулга). Улаанбаатар, 2008, 228 дахь тал.

²⁸ Нарангэрэл С., Тэмүүлэн Н. Зохиогчийн эрх зүйн тулгуур асуудал. Улаанбаатар, 2008. 249 дэх тал.

²⁹ Төрийн мэдээлэл. 1995. № 1.

- Хилийн чанадад нас барсан Монгол улсын иргэний эзэнгүй үлдсэн эд хөрөнгийг өв залгамжлах эсхүл гэрээслэлээр өв залгамжлах.

Төрийн оролцоо бүхий олон улсын эрх зүйн харилцааг дараах үндсэн хоёр төрөлд ангилж болно:

- (1) төр хооронд, түүнчлэн төр хоорондын ба олон улсын байгууллагын хооронд үүсэж буй эрх зүйн харилцаа (эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн хамтын ажиллагаа, зээлийн зэрэг). Энэ төрлийн харилцаа нь гагцхүү олон улсын нийтийн эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагдана. Ийм учраас энэ төрлийн харилцаанд төрийн оролцооны асуудал нь энэхүү судалгааны объект болохгүй;
- (2) Үүсэн буй болсон харилцааны нэг тал нь зөвхөн төр, харин нөгөө тал нь гадаадын хуулийн этгээд, олон улсын аж ахуйн байгууллага (засгийн газар хоорондын бус) болон тодорхой иргэн болж байгаа бол. Харин энэ төрлийн харилцаа энэхүү судалгааны объект болно.

“МОНГОЛ-ОЙРАДЫН ЦААЗЫН БИЧИГ”-ИЙН ТУХАЙ

Н. Улаан-Од¹

Нэг

Монгол-Ойрадын цаазын бичиг бол 1640 онд зохиогдсон. Тус цаазын бичиг гарахаас өмнөх үеийн монголчуудын нийгэм улс төрийн байдал гэвэл нэг талаасаа 1616 онд Зүүн хойт оронд Зүрчин үндэстэн хүчирхэгжин мандаж хойт Алтан улсыг байгуулсан бөгөөд 1636 онд Цахарын Лигдэн хааны засаг төрийг нураагаад хойт Алтан улсаа Чин улс гэж нэрлэв. Ингээд говийн өмнөх Өвөр Монголын 16 аймаг 49 хошуугаараа Чин улсыг дагав.

Ийнхүү Монголын улс төрийн төв нь говийн өмнөх Өвөр Монголын цахар түмдээс Илий голын сав нутгаар оршин байсан Ойрад Монголд шилжсэн байна. Нөгөө талаар XIV зууны сүүлч XVII зууны эхээр Хаант Оросын түрэмгийлэх хүчин Уралын уулсыг даваад Дөрвөн Ойрадын захиргаанд байсан Хиргис түмэн болон бараг Буриадын нутаг дэвсгэрт Хаант Оросын түрэмгийлэх үйл ажиллагаа хэцүүдэж ирсэн байна. Энэчлэн зуу гаруй жил гадаадын халдлага довтолгоо, дарлалын гаслан зовлонг ханатал амссан Дөрвөн Ойрадын феодал ноёд дотооддоо нэгдэл, нягтралыг чангатгаж, гадаадын түрэмгийллийн эсрэг идэвхийлэн тэмцэж байв. Иймэрхүү ахуй байдалд Зүүнгар аймгийн Баатар хун тайж болон Халхын Засагт ханы хамтын чармайлтаар 1640 оны Билгийн улирлын 8 дугаар сарын шинийн таванд Зүүнгарын Баатар хун тайжийн нутаг бөгөөд Халх Монголоос Дөрвөн Ойрадын нутагт хүрэх замын уулзвар болох Тарвагатайн Манит Гаталгаа гэдэг газар Халх, Ойрадын ноёдын их чуулган болж, түүхэнд алдаршсан Монгол, Ойрадын их хурлыг хуралдуулж, бүгдээр дотоодын нэгдэл нягтралаа чангатгах, засаг төрөө аврах их үйл хэргийг зөвлөлдөн “Монгол-Ойрадын цаазын бичиг”-ийг санал нэгтгэйгээр батлан тогтоосон байдаг.

Зүүнгарын их хурлаас “Монгол-Ойрадын цаазын бичиг”-ийг анх худам монголоор бичиж зарласан байна. Үүнээс найман жилийн дараа буюу 1648 онд тод үсэг зохиогдсоны хойно дахин тод үсэгт хөрвүүлэн говийн ар болон баруун талын Монгол нутгаар тархаав. Гэвч уул худам монгол бичмэл эх нь нэгэнт олдохоо болиод бидэнд уламжлагдан ирсэн нь тод үсгээр хөрвүүлсэн бичмэл ба тод үсгийн гар бичмэлийг дахин худам монгол бичгээр хөрвүүлсэн зүйлс болох юм.

Хоёр

“Монгол-Ойрадын цааз бичиг”-ийн гол агуулга бол ноёдын хоорондох харилцааг зохицуулж дотоод нэгдэл нягтралыг чангатгах, харийн түрэмгийллийн эсрэг Монгол, Ойрадын хамтарман хүчнийг зохион байгуулах, шарын шашны эрх нөлөөг дэлгэрүүлэх, харьяат хамжилгаа захирах эрх мэдлийг хууль цаазны үүдээс улам бататган феодалын ноёрхогч ангийн

¹ Өвөр Монголын их сургуулийн дэд профессор